

ГАРЧИГ

Товч танилцуулга

Үндсэн үзүүлэлт

I.Нийгмийн үзүүлэлт

I.1 Хүн ам

I.2 Хөдөлмөр

I.3 Нийгмийн даатгал, нийгмийн халамж

I.4 Эрүүл мэнд

I.5 Гэмт хэрэг

II.Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Банк

II.2 Төсөв

II.3 Үнэ

II.4 Хөдөө аж ахуй

II.5 Аж үйлдвэр

II.6 Тээвэр, холбоо

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН

2017 ОНЫ 11 САРЫН ТАНИЛЦУУЛГА


I. Нийгмийн үзүүлэлт



I.1. Хүн ам

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 11 сард 2205 хүүхэд шинээр мэндэлж, 549 хүн нас барсан байна. Хүн амын цэвэр өсөлт 1656 болж өмнөх оны мөн үеийнхээс 11.0 хувиар буурчээ. Оны эхний 11 сарын байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 19.3, 1000 хүнд ногдох нас баралт 4.8 байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад төрөлт 1.7 пунктээр, нас баралт 0.2 пунктээр буурсан байна.

Төрөлт, нас баралт



I.2 Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1417 болж өмнөх оны мөн

үеийнхээс 1034 хүнээр буюу 42.2 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 859 буюу 60.6 хувь нь 16-34 насны залуучууд байна. Эхний 11 сарын байдлаар ажилгүй 473 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй иргэдээс 308 иргэн ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 27 нь төрийн болон төсөвт байгууллагад, 224 нь нөхөрлөл, компанид ажилд оржээ.



I.3 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого эхний 11 сард 56.5 тэрбум төгрөг, зарлага 55.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 4.8 тэрбум төгрөг буюу 9.3 хувиар, зарлага 4.0 тэрбум төгрөг буюу 7.8 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогын 13.2 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, 80.5 хувийг тэтгэврийн даатгалын сангийн орлого, 0.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, 2.1 хувийг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах даатгалын сангийн орлого, 3.2 хувийг тэтгэмжийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 6.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн даатгалд даатгуулагчдын 59.2 хувь нь заавал даатгуулагчид, 40.8 хувь нь сайн дураар даатгуулагчид байна. Сайн дураар даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 3239 хүнээр буюу 26.0 хувиар буурчээ. Заавал даатгуулагчдын 42.2 хувь нь аж ахуйн нэгж байгууллагад, 57.8 хувь нь төсөвт байгууллагад ажиллаж байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас эхний 11 сарын байдлаар /давхардсан тоогоор/ 37992 хүнд 10.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж өмнөх оны мөн үеээс 13.3 хувиар өссөн байна.


Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын 6.2 хувийг халамжийн тэтгэвэр авагчид, 6.0 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдагсад, 26.5 хувийг ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид хамрагдагсад, 2.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлтөд хамрагдагсад, 0.1 хувийг алдар цолтой ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлтөд хамрагдагсад эзэлж байна.



I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 11 сард 2196 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 268 эхээр буюу 10.9 хувиар, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2205 болж 265 хүүхэд буюу 10.7 хувиар тус тус буурсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Нэг хүртэлх насандаа 39 хүүхэд эндсэн ба өмнөх оны мөн үед нялхасын эндэгдэл 52 байсан байна. 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 10 байгаа ба энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 10 хүүхдээр буурсан байна.

Халдварт өвчнөөр эхний 11 сард 1045 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 2.0 дахин буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 36.6 хувийг салхинцэцэг, 22.1 хувийг тэмбүү, 7.3 хувийг загхүйтэн өвчний тохиолдол эзэлж байна.



I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 11 сард 477 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хэргээр өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 66.7 хувь нь сумдад, 33.3 хувь нь аймгийн төвд гарсан байна. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 15 гарсан ба өмнөх оны мөн үед мөн 32 тохиолдол гарч байсан байна. Хулгайлах гэмт хэргийн 19.1 хувийг малын хулгай эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдсон 380 сэжигтэн, яллагдагчийн 218 хүн буюу 57.4 хувь нь 18-35 хүртэлх насных, 142 хүн буюу 37.4 хувь нь 35-аас дээш насных, 20 хүн буюу 5.3 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 40.8 хувь нь ажилгүй иргэд байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1422 хэрэг илэрч өмнөх оны мөн үеэс 4.8 дахин өсч, авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 2 дахин өссөн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 41-ээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 1007.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 122.9 сая төгрөг буюу 13.8 хувиар өсчээ. Нийт хохирлын 34.3 хувь буюу 345.7 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэргийн улмаас 50 хүн нас барж, 175 хүн гэмтсэн байна.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Банк

Арилжааны банкуудын мэдээгээр аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 11 сарын байдлаар 171.4 тэрбум төгрөг болжээ. Нийт зээлийн 1.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Байгууллага иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 106.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 22.9 тэрбум төгрөг буюу 27.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны мөн үеийнхээс зээлжигчийн тоо 2152 хүн буюу 6.3 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 0.04 хувиар өссөн байна.




II.2 Төсөв

Орлого

2017 оны эхний 11 сард орон нутгийн төсвийн орлогод 11.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 86.4 хувьтай байна. Орон нутгийн орлогын 67.6 хувь нь татварын орлого, 10.4 хувь нь хөрөнгийн албан татвар, 21.9 хувь нь бусад татвар, төлбөр хураамжийн орлого байна.


Татварын орлогын бүтэц



Зарлага

Төсвийн зарлага 63.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1.7 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар нэмэгдсэн байна. Нийт зарлагын 71.4 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 20.0 хувийг урсгал шилжүүлэг, 5.7 хувийг хөрөнгийн зардал, 0.2 хувийг татаас, 2.8 хувийг эргэж төлөгдөх зээл эзэлж байна.

Төсвийн зарлагын бүтэц



II.3 Хэрэглээний үнийн индекс


Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 2.8 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа үйлчилгээний нэр төрлөөр харвал гутал хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнэ буурч, бусад бүлгийн үнэ өссөн байна. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеийнхээс 2.8 хувиар өсөхөд эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг болон бусад бүлгийн үнэ 0.3-9.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



II.4 Хөдөө аж ахуй


Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцэст төллөх насны нийт 2092.9 мянган эх мал тоологдсон ба 2017 оны эхний 11 сарын байдлаар 1896.2 мянган толгой эх мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 90.6 хувь нь төллөсөн байна. Ингэний 50.4 хувь, гүүний 87.6 хувь, үнээний 89.0 хувь, эм хонины 92.5 хувь, эм ямааны 89.4 хувь нь төллөжээ. Өмнөх оны мөн үед нийт эх малын 99.9 хувь буюу 1660.6 мянган мал төллөсөн байжээ.

Мал төлөлтийн хувь




Гарсан төл 97.1 хувьтай бойжиж байна. Ботго 99.2 хувь, унага 99.4 хувь, тугал 99.3 хувь, хурга 98.3 хувь, ишиг 95.1 хувьтай бойжиж байна. Өмнөх оны мөн үед төл бойжилтын хувь 98.4 хувьтай бойжиж байсан байна.

Төл бойжилтын хувь



Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар оны эхэнд тоологдсон нийт малын 0.5 хувьтай тэнцэх 23.5 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байна. Нийт хорогдсон малын 0.1 хувийг тэмээ, 2.7 хувийг адуу, 3.1 хувийг үхэр, 37.5 хувийг хонь, 56.7 хувийг ямаа эзэлж байна.

Том малын зүй бусын хорогдол



Эхний 11 сарын байдлаар өвчнөөр 984 толгой мал хорогдсон байна. Нийт 2 тэмээ, 61 адуу, 58 үхэр, 381 хонь, 482 ямаа өвчнөөр хорогдоод байна.

Нийт хорогдсон том малын 7176 буюу 30.5 хувь нь хээлтэгч мал байгаа ба хээлтэгчийн хорогдлын 53.5 хувийг ямаа эзэлж байна.


Аймгийн түүхий эдийн захад ямааны ноолуур 68.0 мянган төгрөг, тэмээний шир 15.0 мянган төгрөг, адууны шир 21.0 мянган төгрөг, үхрийн шир жижиг нь 25.0 мянган төгрөг, том нь 30.0 мянган төгрөг, хонины нэхий 2000 төгрөг/өлөн гэдэс ороогүй үнэ/, ямааны арьс/өлөн гэдэсгүй/ 27.0 мянган төгрөг, адууны дэл 8.5 мянган төгрөг, адууны сүүл 6.0 мянган төгрөгийн үнэ ханштай байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад малын гаралтай түүхий эдийн үнэ ихэнх төрөл дээр өссөн үзүүлэлтэй байна.

Тухайлбал ноолуур 33.3 хувиар, адууны дэл 2 дахин, хонины нэхий 3 дахин, ямааны арьс 35.0 хувиар, үхрийн шир 19.0 хувиар тус тус өссөн, адуун шир 40.0 хувиар, адууны сүүл мөн 40.0 хувиар тус тус буурсан ба үхрийн том шир мөн үеийн түвшинд байна.

Өмнөх сартай харьцуулбал адууны дэл 21.4 хувиар, адууны шир 31.3 хувиар, үхрийн жижиг шир 25.0 хувиар, үхрийн том шир 7.1 хувиар, хонины нэхий 66.7 хувиар, ямааны арьс 4 дахин тус тус өсч, ноолуур 2.9 хувиар, адууны сүүл 25.0 хувиар, тэмээний шир 16.7 хувиар тус тус буурсан байна.

Малын гаралтай зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ



Аймгийн хэмжээнд 8217.5 га-д үр тариа тариалсан ба үүний 8102.5 га-д буудай, 5.0 га-д арвай, 110 га-д овъёос тариалжээ. Үр тариа тариалалт өмнөх оноос 2513.8 га-р илүү хийгдсэн байна. Энэ онд 395.1 га-д төмс, 213.6 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад төмс 20.0 га-гаар, хүнсний ногоо 7.7 га-гаар илүү тариалсан байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр 2094 тн буудай, 4 тн арвай, 15 тн овъёос, 3917.6 тн төмс, 2020.0 тн хүнсний ногоо, 1.5 мянган тн малын тэжээл, 102 тн рапс хураан аваад байна.

Малчдын өөрсдийн бэлтгэсэн хадлан 14.8 мянган тн, гаднаас худалдаж авсан нь 13.6 мянган тн байна. Нийт бэлтгэсэн хадлан нь өмнөх оны мөн үеээс 0.4 мянган тн-оор илүү байна. Гар тэжээл 6.0 мянган тн-ийг бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеээс 0.7 мянган тн-оор илүү байна. Жилийн эцсийн мал тооллогын мэдээгээр энэ мэдээлэл нь нэмэгдэж гарах болно.




II.5 Аж үйлдвэр

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 11 сард 21.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 21.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.5 хувиар, борлуулалтын орлого 5.2 хувиар өссөн байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд: чулуун нүүрс, түгээсэн ус, сувагжуулалт, сүү сүүн бүтээгдэхүүн, бялуу, хэрчсэн гурил, архи, цэвэр ус, оёдол, төмөр эдлэл хийц, нүдний шил зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.5 хувиас 3.0 дахин өссөн байна. Харин дулаан, талх, нарийн боов, хөлдөөсөн бууз, дарсан ногоо кимчи, хиам, гутал, гэрийн мод, блок, тоосго, хэвлэх үйлдвэрлэл 7.7-67.4 хувиар буурсан байна.


Бүтээгдэхүүн үйлдвэрлэл сая төгрөг



II.6 Холбоо, тээвэр

Тээвэр: Авто замын тээврээр эхний 11 сард давхардсан тоогоор 253.8 мянган зорчигч зорчиж, 34.8 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 27.3 мян.хүн буюу 12.1 хувь, тээсэн ачаа 2.7 мян.тн буюу 8.4 хувиар өсчээ.

Зорчигчдын тоо, тээсэн ачаа



Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2480.5 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 251.9 сая төгрөг буюу 11.3 хувиар өсчээ.

Холбоо: Холбооны орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 20.6 хувиар буурч 518.7 сая төгрөг болсоны дотор хүн амаас орсон орлого 49.7 хувиар буурч 109.9 сая төгрөг болсон байна. Телефон цэгийн тоо 670 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 83-аар буурсан байна.